

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2023 оны 12 дугаар сард хийсэн ажлын товч мэдээ

2023 оны 12 дугаар сарын 22

Дархан-Уул аймаг

Аймгийн Засаг даргын баталсан “Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2023 онд хийх хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Хараа Ерөө голын сав газрын захиргааны үйл ажиллагаанд дотоод аудит хийж дуусган илэрсэн асуудалд 5 зөвлөмж, өглөө. Мөн Замын сан, Эрүүл мэндийн газрын үйл ажиллагаанд хийсэн санхүүгийн хяналт шалгалтыг дуусган илэрсэн асуудалд Замын санд 4 зөвлөмж, Улсын ахлах байцаагчийн 1 албан шаардлага, Эрүүл мэндийн газарт илэрсэн зөрчилд 16,0 сая төгрөгийг төсвийн орлогын дансанд төвлөрүүлэх, 17.2 сая төгрөгийг ажиллагсад нөхөн олгох арга хэмжээ авахуулахаар шийдвэрлэн улсын ахлах байцаагчийн 8 акт тогтоож, зөрчил арилгуулахаар улсын ахлах байцаагчийн 1 албан шаардлага, 10 зөвлөмж хүргүүлсэн.

Мөн Дархан-Уул аймаг дахь бүсийн Шүүх шинжилгээний төвийн 2021-2022 оны санхүүгийн баримтад дотоод аудит хийж дуусган дотоод аудитаар 7 зөрчил илрүүлсэн. Дотоод аудитын ажлын баримтуудыг албаны даргаар хянуулж байна. БШУГ, Залуучууд театрын 2021, 2022 оны санхүүгийн баримтуудыг шалгаж дуусган сонсох ажиллагааг хийж байна.

Дотоод аудитын хорооны хурал хийхтэй холбогдуулан 2023 оны 2,3,4-р улиралд шалгагдсан байгууллагын акт, албан шаардлага, зөвлөмж, биелэлтийг гарган хурлаар хэлэлцүүлж холбогдох тогтоолыг гаргууллаа.

2023 оны ТЖАХ-ийн гүйцэтгэлийн тайланг 7 албан хаагч гарган албаны даргад хүргүүлж үнэлүүллээ.

Албаны үйл ажиллагаатай холбоотой дараах мэдээ тайлан судалгааг холбогдох газарт хүргүүлэв. Үүнд:

- Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх иргэнд дэмжин туслах "1/5" аяны хүрээнд тус албанаас 2023 онд зохион байгуулсан арга хэмжээний тайланг ХХҮГазарт
- Албан хаагчдын судалгаа болон байцаагчийн эрх олгох хүсэлтийг Сангийн яамны СХЭУГ-т
- Санхүүгийн алба үүсгэн байгуулагдсаны 112 жилийн ойн хүрээнд албаны 2 албан хаагчийг Сангийн яамны шагналаар, 2 албан хаагчийг Дархан сумын Засаг даргын жуух бичгээр шагнуулах хүсэлтийг Аймгийн ЗДТГ-ын СТСХ-т тус тус хүргүүлж шийдвэрлүүлэн ойн арга хэмжээний үеэр гардууллаа.

➤ 2023 оны жилийн эцсийн худалдан авах ажиллагааны тайлан, 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тус тус Орон нутгийн өмчийн газарт

➤ 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудит хийгдэхтэй холбогдуулан холбогдох судалгааг гаргаж Пийк ом аудит ХХК-д

➤ 2023 оны иргэдээс өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайланг 4 дүгээр улирлын байдлаар гарган АЗДТГ-ын ТЗУХ-т

➤ Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн зөрчлийн мэдээг жилийн эцсийн байдлаар гаргаж Дархан-Уул аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд

➤ Мэдээллийн ил тод, нээлтэй байдлын хэрэгжилтийн тайланг гарган АЗДТГ-ын ТЗУХ-т

➤ Дархан-Уул аймгийн авилга, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилсан сэргийлэх дэд хөтөлбөрийн хэрэгжилт, авлигын эсрэг төлөвлөгөөний биелэлтийг 2023 оны жилийн эцсийн байдлаар гаргаж АЗДТГ-ын ХЭЗХ-т

➤ Байгууллагын гүйцэтгэлийн гүйцэтгэлийн тайлан, жилийн үйл ажиллагааны үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, аргачлал, шилэн дансны 3-р улирлын тайлан, Өрсөлдөх чадварын мэдээллийн товч тайланг тус тус АЗДТГ-ын ХШҮХ-т

➤ Дархан-Уул аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс ирүүлсэн 180,181 дүгээр албан бичиг ирсэний дагуу 15 хавсралт бүхий судалгааг гарган хүргүүлсэн.

Дараах сургалт арга хэмжээнд албан хаагчид оролцлоо. Үүнд:

➤ Төрийн байгууллага, албан хаагчдад харилцааны соёл, үйл ажиллагаандаа баримтлах дэг, жаягийг нийтлэг байдлаар танилцуулах, анхаарал хандуулах зарим асуудлаар танин мэдэхүйн болон практик мэдээлэл зөвлөмж өгөх зорилгоор ТАЗ-өөс зохион байгуулж буй 7:4:10 “Сайн түшмэдтэй төр л сайн төр байж чадна” сэдэвт цахим сургалтад 9 албан хаагч хамрагдлаа.

➤ ISO9001:2015 Чанарын менежментийн тогтолцоог байгууллагад нэвтрүүлэхээр холбогдох дотоод сургалт, үйл ажиллагааны судалгааг хийж байна.

➤ Хэлтэс агентлагийн нар нарын хурал, Иргэдийн индэрийг АЗДТГ-аас зохион байгуулахад албаны дарга оролцсон.

➤ ММНБИ-ийн Дархан салбараас МНБ нарт зохион байгуулсан сургалтад 2 албан хаагч оролцлоо.

➤ “Авлигын эсрэг олон улсын өдөр” болгон тунхагласныг угтан аймгийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулж буй “Үл тэвчье, үл эвлэрье” өдөрлөг болж 1 албан хаагч хамрагдлаа.

➤ Дархан-Уул аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс төрийн албан хаагчдад зорилсан модуль сургалтад 2 албан хаагч

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБА